



## СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/Б47

Улаанбаатар хот

### Жендэрийн салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”, Жендэрийн үндэсний хорооны 2022 оны “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө”, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 1.3, 2.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн дэргэдэх “Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Байгууллагын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр ажлаа тайлагнаж ажиллахыг Жендэрийн салбар зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга (П.Ундрах)-д даалгасугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.УУГАНЦЭЦЭГ

132511676

СЭМҮТ-ийн захирлын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгчийн 2025 оны .... дугаар сарын ...  
-ны/ний өдрийн А/... дугаар тушаалын хавсралт



ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга

П.Ундрах

Нарийн бичиг:

Хүний нөөцийн мэргэжилтэн

Г.Номуун

Гишүүд:

Эдийн засаг, даатгалын албаны дарга

Г.Маналжав

Мэдээллийн технологийн албаны дарга

Х.Цогтбаяр

Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

А.Саранцэцэг